



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/17

Даланзадгад сум

“Эрүүл шүд хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- Амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулан, урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “Эрүүл шүд” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.
- Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА:



О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ

4625010049

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн
4/17 дугаар тогтоолын хавсралт

“ЭРҮҮЛ ШҮД” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, өвчлөл, нас барагтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийн эрүүл дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Өсөлттэй Өмнөговь” үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрийн дараах хэсгүүдэд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр зорилт арга хэмжээ тусгагдсан. Тухайлбал:

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1 дэх хэсэгт “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэл тусгагдсан.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн А/379 дугаар “Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд сууринсан зонхилон тохиолдох халдварт бус өвчинөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээг зохион байгуулах журам” тушаалаар үзлэгийн үр дүнд 0-17 насны хүүхдийн өвчлөлийн 255,998 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн тохиолдоос шүд цоорох 198,906 буюу 77.7%, шүдний гажиг 7,403 буюу 2.9%, хараа муудах 3,013 буюу 1.2%-ийг эзэлж тэргүүлэх өвчлөл болж байна. Бүртгэгдсэн шүд цоорох өвчний 164,573 тохиолдол буюу 82.7%-ийг 6-17 насны хүүхэд эзэлж байна. Харин 0-5 насны хүүхдийн 44,603 өвчлөлийн сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн 77.0% нь шүд цоорох, 5.1% нь амьсгалын дээд замын эмгэг, 2.5% нь шүдний гажиг эзэлж байна.

“Эрүүл шүд” хөтөлбөрийг хүрээнд аймгийн хэмжээнд 7 сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинет, хувийн хэвшлийн 8 шүдний эмнэлэг, “Говь дент” шүдний төв, БОЭТ зэрэг нийт 16 кабинет, төрийн 7 байгууллагын нийт 13 эмч, 5 сувилагч ажиллаж амны хөндий, шүдний тусламж үйлчилгээ 2020 онтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн байна.

Амбулаториор 10,5263 хүнд үйлчилгээ үзүүлсэн байна. 2020 онд 18,877 байсан бол 2024 онд 35,430 иргэн болж 2 дахин нэмэгдсэн байна. Үүнээс өвчний учир 68,420/65% /урьдчилан сэргийлэхээр 36,843/35%/ иргэн байна. Илэрсэн өвчлөлийн 75 хувьд нь эмчлэн эрүүлжүүлэх ломбо, түрхлэг зэрэг тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Мөн Даланзадгад суманд “Говь дент” шүдний төвийг байгуулан 14,172 иргэнд амны хөндийн тусламж үйлчилгээ, 3424 /25.6%/ иргэнд урьдчилан сэргийлэх үзлэг, 10,748 /73.5%/ иргэнд өвчний учир амбулаторийн үзлэг иргэдэд үнэ төлбөргүй тусламж үйлчилгээ хүргэсэн байна. Энэ нь иргэдийн шүдний кабинетад үүсгэх ачааллыг 2 дахин бууруулж чадсан юм. 2024 оны байдлаар шүд цоорлын тархалт 6 настай хүүхдүүдийн дунд 84.3%-тай, 6 настай хүүхдүүдийн дунд цоорлын эрчим 6,12-той, 12 насны хүүхдийн дунд шүд цоорлын тархалт 86.6%, шүд цоорлын эрчим 4.5, насанд хүрэгчдийн шүд цоорлын тархалт 72.3%-тай байна. Тусламж үйлчилгээ авсан нийт хүмүүсийн шүд цоорлын тархалтын түвшин 81% байна. Үүнээс эмчлэн эрүүлжүүлсэн иргэдийн тоо 59.4% (51,315 хүн) байна. Энэ нь шүд цоорлын тархалтын түвшин 70.2% буюу 10.8%-аар буурсан байна.

Цаашид шүд цоорлын тархалт болон цоорлын эрчмийг бууруулахын тулд иргэдийн амны хөндий эрүүл ахуй, хүнсний бүтээгдэхүүний зөв сонголт, эрүүл мэндийн зохистой дадлыг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхийн тулд хүн амын насны онцлогт тохирсон сургалт, сурталчилгааг тасралтгүй зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийг тусламж үйлчилгээг шат шатны эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан өргөжүүлэх нэн шаардлагатай байна.

Мөн амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх. Мөн хөдөө орон нутагт шүдний кабинетын үйл ажиллагааг тогтвортжуулах, амны хөндийн эрүүл мэндийн

чиглэлд шинэ технологи нэвтрүүлэх, хүний нөөцийг бэлтгэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний чадавхыг дээшлүүлэх хэрэгтэй.

Иймд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр иргэдийг эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх “Эрүүл шүд” хөтөлбөрийг хэрэгжүүлэх шарлагатай байна.

Аймгийн Засаг даргын “Өсөлттэй Өмнөговь” 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1.5 дэх заалтад амны хөндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, өвчлөлийг бууруулах зорилгоор “Эрүүл шүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээг өмнөх турслага, чадавх дээрээ тулгуурлан хэрэгжүүлж, хөтөлбөрийг ирэх 2025-2028 онд илүү үр дүнтэй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Шүдний тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөв дадал хэвшилд иргэдийг төлөвшүүлэх замаар амны хөндийн өвчлөлийг бууруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагын амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг сайжруулах.

Зорилт 2. Шүд, амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, эрүүл зан үйл төлөвшүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Өмнөговь аймгийн нийт хүн ам болон хөдөлгөөнт хүн ам.

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1.Сумдын эрүүл мэндийн төвүүдэд шүдний кабинетыг шинээр байгуулах, үйл ажиллагааг тогтмолжуулахад шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах;

5.1.2.Шүдний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох;

5.1.3.Хүн амд амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэх;

5.1.4.Нүүр ам судлалын үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтворт суурьшилтай ажиллуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх;

5.1.5.Амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэх явуулын багийг төр, хувийн хэвшлийн эмнэлгүүдэд түшиглэн байгуулах, алслагдсан баг, суманд ажиллуулах.

5.2. Хөтөлбөрийн 2 дугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.2.1. 6, 12 настай хүүхдийг шүдний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрдэсжүүлэх арга хэмжээ зохион байгуулах;

5.2.2.Сургууль, цэцэрлэг болон албан байгууллага, аж ахуйн нэгж ажлын байранд шүд угаах хэсэг-шүд угаах цагийг бий болгож, шүд угаах дадлыг төлөвшүүлэх;

5.2.3.Сургууль, цэцэрлэгийн эмч, эрүүл мэндийн багш нарыг амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр чадавхжуулах;

5.2.4.Сургууль, цэцэрлэгийн байгууллагыг түшиглэн хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулж, дадал бий болгох;

5.2.5.Хүн амын дунд шүд, амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, эрүүл зан үйл төлөвшүүлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

Хөтөлбөрийг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

- 7.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:
- 7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв
 - 7.1.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив
 - 7.1.3. Бусад эх үүсвэр

Найм. Хөтөлбөрийн хүлээгдэж буй үр дүн

- 8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр иргэдийн шүдний өвчлөл буурч, бага насны хүүхдийн архаг болон суурь өвчлөлөөс сэргийлэх боломжтой.
- 8.2.Сумдын эрүүл мэндийн төвүүдийн 80 дээш хувь нь амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүргэх боломжтой болно.
- 8.3.Зорилтот бүлгийн 6, 12 настай хүүхдүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, шүд хамгаалах фтор түрхлэг буюу эрдэсжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхдүүдийн дундах шүдний өвчлөлийг бууруулна.
- 8.4.Орон нутагт ажиллаж буй шүдний эмч, сувилагч, эрүүл ахуйчийн орон тоог нэмэгдүүлж, хүний нөөцийг чадавхуулж амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ.
- 8.5.Шүдний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгож, иргэдэд хүртээмжтэй болгоно.
- 8.6.Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй зохион байгуулж, амны хөндийн эрүүл мэндийн зөв дадалтай болгож, шүдний өвчлөлийг бууруулна.

Ес. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг

- 9.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна
- 9.2.Хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дүнд сууриссан явцын болон хөндлөнгийн үнэлгээг жил бүр хийлгэнэ.
- 9.3.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

Арав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 10.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, иргэд, олон улсын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Эрүүл мэндийн газар хариуцна.
- 10.2.Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх, биелэлтэд нь хяналт тавих, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагын дарга эрхлэгч нар хариуцан зохион байгуулна.

Арван нэг. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

- 11.1.Хөтөлбөрийн үр дүнг дүгнэхдээ 2024 оны мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ

Эрүүл шүд хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин					Тайлбар
			2024	2025	2026	2027	2028	
1	6 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь	84,3%	84,2%	84,1%	84%	83,9%		Үндэсний эрүүл шүд
2	12 настай хүүхдийн дунд шүд цоорлын тархалтын хувь	86,6%	86,5%	86,4%	86,3%	86,2%		
3	6 настай хүүхдийн дунд шүд цоорлын эрчим (ЦЛА/шүд)	6,12	6,11	6,10	6,9	6,8		
4	12 настай хүүхдийн дунд шүд цоорлын эрчим (ЦЛА/шүд)	4,5	4,4	4,3	4,2	4,1		
5	Шүдний кабинетаар үйлчлүүлэгчдийн тоо	35430	36000	36500	37000	37500		

6	6,12 настай хүүхдийн шүдний эрдэсжүүлэх хийгдсэн хүүхдийн тоо	300	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	Тухайн жил 6, 12 настай хүүхдийн тоо
7	БОЭТ, СЭМТ-д тогтвортой суурьшилтай ажиллаж буй шүдний эмч, сувилагчийн тоо	11 эмч, 4 сувилагч	1 эмч	1 сувилагч	1 эмч	1 сувилагч	Эмч, сувилагч нэмэгдэх тоо
8	Бэлтгэгдсэн нүүр амны эрүүл ахуйчийн тоо	1	0	1	0	1	
9	Бүртгэгдсэн өвчлөлийн эмчлэн эрүүлжкуулсан хувь	75%	77%	80%	82%	85%	
10	Амны хөндийн тусlamж үйлчилгээ үзүүлж буй байгууллагын тоо	7	8	8	9	9	
11	Нийгмийн эрүүл мэндийн сургалт нэлөөллийн арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	950	1000	1100	1200	1300	
12	Шүд угаах хэсэг байгуулсан албан байгууллагын тоо	14	16	18	20	22	

oOo